



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/662

Мандалговь

Г Багш, сурагчдад урамшуулал олгох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ийн "а", аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Урамшууллын жишиг тогтоох журам"-ын 1.2, 3.1, 3.2, 3.2.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 9 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2017-2018 оны хичээлийн жилд зохион байгуулагдсан Улсын төрөлжсөн олимпиадын гурвын даваа болон уртын дуучдын улсын уралдаанд амжилттай оролцож, эхний гурван байранд шалгарсан сурагчид, бэлтгэн оролцуулсан багш нарыг шагнаж урамшуулсугай.

Хоёр. Урамшууллын зардлыг хавсралтаар баталсугай

Гурав. Урамшуулалд олгох 360.000 (Гурван зуун жаран мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200760

Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын
12-ны өдрийн 4362 тоот захирамжийн хавсралт

Урамшуулал олгох сурагчдын жагсаалт

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Оролцсон тэмцээн, төрөл	Эзэлсэн байр	Олгох урамшуулал
1	Б.Балжинням	ЗА00261311	Улсын төрөлжсөн олимпиадын гурвын даваа "Монгол бичиг"	3-р байр	100.000
2	А.Нямдэлгэр	ЗМ00230501	Улсын төрөлжсөн олимпиадын гурвын даваа "Дүрслэх урлаг" –ийн төрөл	3-р байр	100.000
3	З.Мийгар	ЗЖ99062912	Уртын дуучдын улсын уралдаан	3-р байр	60.000
ДҮН					260.000

Урамшуулал олгох багш нарын жагсаалт

№	Бэлтгэсэн багш овог, нэр	Регистрийн дугаар	Бэлтгэж оролцуулсан тэмцээн, төрөл	Бэлтгэсэн тамирчны гаргасан амжилт	Олгох урамшуулал
1	Д.Отгонсүрэн	ЗМ74071206	Улсын төрөлжсөн олимпиадын гурвын даваа "Монгол бичиг"	3-р байр	50.000
2	Н.Батжаргал	ЗП95040811	Улсын төрөлжсөн олимпиадын гурвын даваа "Дүрслэх урлаг"-ийн төрөл	3-р байр	50.000
ДҮН					100.000